



Тос

МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ
САНХҮҮГИЙН ХОЛБОО

ГИШҮҮНЧЛЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ, ӨРГӨДЛИЙН МАЯГТ



ТoС ХОЛБООНЫ ТУХАЙ	3
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	3
ТoС-ИЙН ЗӨВЛӨЛҮҮД	4
ГИШҮҮНЧЛЭЛИЙН АНГИЛАЛ.....	5
ЯАГААД ТoС ХОЛБООНД ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ВЭ?.....	5
ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ	6
ХЭРХЭН ГИШҮҮН БОЛОХ ВЭ?.....	8
ХАВСРАЛТ 1: ӨРГӨДЛИЙН МАЯГТ	9
ХАВСРАЛТ 2. ТoС-ИЙН ЗАРЧМУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУНХАГ БИЧИГ	13
ХАВСРАЛТ 3. ГИШҮҮНЧЛЭЛИЙН СУУРЬ ШААРДЛАГА.....	14

ТоС ХОЛБООНЫ ТУХАЙ



“Эерэг
санхүүжилтийг
түгээн дэлгэрүүлье”



“Монгол Улсыг бүс
нутагтаа тогтвортой
санхүүжилтийн манлайлал,
мэдлэгийн төв болгоно”



“Хамтын ажиллагаа,
Хүртээмж,
Дэвшил”

Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (“ТоС Холбоо”)–г 2017 оны 12 дугаар сард гишүүддээ үйлчилдэг ТББ хэлбэрээр үүсгэн байгуулсан бөгөөд ТоС Холбоо нь Монгол Улсын санхүүгийн салбар болон бизнесийн байгууллагуудад байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, тогтвортой санхүү, ногоон зээл, хөрөнгө оруулалтын дэд бүтэц бүрдүүлж, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг манлайлан ажиллах зорилготой юм. Уг зорилгын хүрээнд ТоС Холбоо нь одоогийн байдлаар арилжааны нийт 12 банкиг гишүүнчлэлдээ нэгтгэн ажиллаж байгаа бөгөөд тогтвортой санхүүжилт, ногоон эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр тулгамдаж буй асуудлуудад гишүүдийг нэгтгэн чиглүүлж, санал шийдэл боловсруулдаг.

Нэмэлт мэдээллийг ТоС Холбооны брошур, www.toc.mn цахим хуудаснаас авна уу.

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ТоС Холбооны Удирдах зөвлөл нь үндсэн гишүүн байгууллагуудын гүйцэтгэх захирал, гүйцэтгэх захирлын орлогчийн албан тушаалтай удирдах албан тушаалтнаас бүрддэг бөгөөд удирдах зөвлөлийн даргыг жил бүр тухайн жилд ТоС Хөтөлбөрийг манлайлан ажиллахаар сонгогдсон байгууллагаас тодруулдаг уламжлалтай. Холбооны Удирдах зөвлөл нь улирал бүр хуралддаг.

ТоС-ийн зөвлөлүүд

Бид үйл ажиллагааныхаа зорилгын хүрээнд гишүүн байгууллагууд дээрээ тулгуурлаж, аль нэг гишүүн байгууллагаар ахлуулсан зөвлөлүүдийг байгуулан ажиллаж байна.



ТоС Зөвлөл

Уг зөвлөл нь нийт гишүүн байгууллагууд болон Монголбанк, СЗХ, БОАЖЯ, ОУСК зэрэг хамтрагч байгууллагуудын төлөөллийг хамардаг бөгөөд ТоС-ийн чиглэлээр цаг үеийн асуудлуудыг хэлэлцэж, сар бүр тусгайлсан сэдвээр мэдээлэл, туршлага солилцох хэлэлцүүлгийг өрнүүлдэг.

ТоС ажлын хэсгүүд



1. Байгаль орчин нийгмийн эрсдэлийн удирдлагын ажлын хэсэг

Зорилго: Гишүүн байгууллагуудын Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын системийг сайжруулах, олон улсын чиг хандлага, стандарттай нийцүүлэх чиглэлээр ажиллаж, гишүүн байгууллагуудад зориулсан жишиг бодлого, журам, эрсдэлийн үнлэгээний аргачлал зэргийг боловсруулах.

2. Тогтвортой тайлагналын ажлын хэсэг

Зорилго: GRI, TCFD, Global Compact, CDP зэрэг олон улсын тайлагналын стандартууд болон дотоодын сайн туршлагаудыг тусгасан тогтвортой байдлын тайлагналын удирдамж, гарын авлагыг боловсруулах.

3. Ногоон бодлогын ажлын хэсэг

Зорилго: Банк болон банкны бус салбарт ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэхтэй холбоотой бодлого, урамшууллын тогтолцоог бий болгох зорилгоор судалгаа хийх, зөвлөмжүүд боловсруулах, холбогдох байгууллагуудад хүргүүлэх.

4. Ногоон бүтээгдэхүүний ажлын хэсэг

Зорилго: Эрчим хүчний хэмнэлттэй бизнесийн зээл, ногоон барилга, дулаалалгын зээл зэрэг бүтээгдэхүүний стандарт, зээлийн зураглалыг боловсруулах, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх.

5. Ногоон цахим бүтээгдэхүүний ажлын хэсэг

Зорилго: Ногоон карт, ногоон цахим төлбөр тооцоо зэрэг дижитал бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилго доор байгуулагдсан.

6. Ногоон оффисын ажлын хэсэг

Зорилго: Гадаад, дотоодын ногоон, хүртээмжтэй оффисын сайн туршлага, стандартуудыг тусгасан гарын авлагыг боловсруулах, гишүүдэд зөвлөгөө өгөх.

7. ПиАр, олон нийтийн боловсролын ажлын хэсэг

Зорилго: Гишүүд, хамтрагч болон харилцагч байгууллагууд, олон нийт, иргэдийн дунд тогтвортой санхүүжилтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх.

ГИШҮҮНЧЛЭЛИЙН АНГИЛАЛ

ToC Холбоо нь өөрийн гишүүнчлэлээ өргөжүүлж, зөвхөн арилжааны банкаар хязгаарлахгүй, цаашид санхүүгийн салбарын бусад оролцогч байгууллагуудад гишүүнчлэлээ нээлттэй болголоо. Өөрийн бизнес, санхүүгийн үйл ажиллагаанд [ToC-ийн зарчмуудыг](#) нэвтрүүлэн, тогтвортой хөгжил, ногоон хүртээмжтэй эдийн засагт хувь нэмэр оруулан ажиллах эрмэлзлэлтэй дараах төрлийн байгууллагууд гишүүнээр элсэх боломжтой. Үүнд:



Үндсэн гишүүн: Үндсэн гишүүнд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан арилжааны банк, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаас, брокер, дилерийн компани, сан болон өөрийн салбар, төлөөлөгчийн газраа байгуулсан гадаадын банк санхүүгийн байгууллагууд багтах боломжтой.



Дэмжих гишүүн: Дэмжих гишүүн гэдэгт ToC Холбооны үндсэн гишүүн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэмжих, хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллага, сургалтын байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, салбарын болон мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээний байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад хамтын ажиллагаа бүхий байгууллагууд орно.

Хэн гишүүнээр элсэх боломжтой вэ?

- Арилжааны банкууд / Хөгжлийн банкууд/ Гадаадын банкуудын төлөөлөгчийн газрууд
- Банк бус санхүүгийн байгууллагууд / Хөрөнгийн оруулалтын менежментийн компаниуд
- Тусгай зориулалтын санхүүгийн байгууллагууд (моргейж, батлан даалт гэх мэт)
- Даатгалын компаниуд
- Үнэт цаасны компаниуд / Хөрөнгө оруулагчид
- Мэргэжлийн болон үйлдвэрлэлийн холбоод
- Бизнес, хувийн хэвшлийн байгууллагууд
- Олон улсын байгууллагууд
- ТББ, судалгааны хүрээлэн, сан, иргэний нийгмийн байгууллагууд
- Их дээд сургууль, сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагууд.

ЯАГААД ToC ХОЛБООНД ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ВЭ?



Тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмрээ оруулах



ToC-ийн мэргэшсэн зөвлөгөө, дэмжлэг авах,



Байгууллагын эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх



Холбооноос хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөр, эх үүсвэрүүдэд хамрагдах



Байгууллагын эерэг үйл ажиллагааг тайлагнах, олон нийтэд хүргэх

ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

ToC Холбоонд гишүүн байгууллагаар элссэнээр дараах эрх, үүргийг эдлэх боломжтой.

Үндсэн гишүүний тусгайлсан эрх, үүрэг

- “ТоС Манлайлагч байгууллага”-д нэр дэвших
- Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдох
- Удирдах зөвлөлийн хуралд санал оруулж, хэлэлцүүлэх
- Холбооны үйл ажиллагааны тайлантай танилцах
- Жил бүрийн “Шилдэг ТоС Байгууллага” шагналд нэр дэвших
- Холбооноос боловсруулж баталсан тогтвортой санхүүжилт, байгаль орчин, нийгмийн эрсдэл, ногоон зээл, тогтвортой бизнесийн **бодлого, зарчим, удирдамж, стандартыг үр дүнтэй хэрэгжүүлэх**, хөгжүүлэх, хамтран ажиллах, тусгайлсан зөвлөгөө, дэмжлэг авах
- Холбооноос баталсан тайлангийн маягтын дагуу өөрийн байгууллагын **тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааны талаар тайлан** мэдээг зөвшилцсөн хугацаанд, тогтмол ирүүлэх
- ТоС Холбооны жил бүр хийгддэг **ТоС-ийн хэрэгжилтийн үнэлгээнд** хамрагдах, өөрийн байгууллагад зориулсан тусгай зөвлөмжийг авах, бусад байгууллагуудын **сайн туршлагаас судлах**
- Ногоон санхүүгийн хэрэгсэл боловсруулахтай холбоотой **тусгайлсан зөвлөгөө** авах
- Холбооноос хэрэгжүүлдэг ногоон зээлийн болон бусад холбогдох төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах

Үндсэн болон дэмжих гишүүний эрх, үүрэг

- Заасан мандатын дагуу Холбооны нийт гишүүдийн хуралд оролцох
- Холбооны **гишүүнчлэлийн татварыг** цаг тухайд нь шилжүүлэх
- Холбооны **зөвлөлүүд, ажлын хэсгүүдэд** төлөөллөө оролцуулах, сар бүрийн уулзалтад оролцох
- Холбооноос хэрэгжүүлдэг ногоон зээлийн болон бусад холбогдох төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд хамтран ажиллах
- ТоС-ийн онлайн сургалтын платформ, сургагч багшийн сургалт болон бусад гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарсан сургалтуудад үнэгүй эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр хамрагдах
- Холбооноос зохион байгуулж буй **Форум, арга хэмжээ, уулзалт, хэлэлцүүлэгт** оролцох
- Холбооноос боловсруулдаг **судалгааны ажилд** санал өгөх, мэдээлэл авах, оролцох
- Холбооноос гаргаж буй **хэвлэл мэдээлэл, тайланд** өөрийн байгууллагын ТоС-ийн үйл ажиллагааны талаар дурдуулах, тусгах
- Дотоодод болон олон улсад хэрэгжиж буй тогтвортой санхүүгийн хөгжлийн тухай сар бүрийн **ТоС Цахим товхимол, улирал бүрийн Гүйцэтгэх захирлын хураангуй, жилийн эцсийн тайланг** хүлээн авах
- Гишүүний үйл ажиллагааны онцлогт нийцүүлсэн бусад хамтын ажиллагаа

Хүснэгт 1. Гишүүнчлэлийн матриц

ГИШҮҮНЧЛЭЛИЙН АШИГ ТУС Гишүүнчлэлийн татварын хэмжээ	ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТӨРӨЛ			
	Үндсэн гишүүн			Дэмжигч гишүүн (1 сая)
	Бүлэг 1 (12 сая)	Бүлэг 2 (8 сая)	Бүлэг 3 (4 сая)	
1. Нийт гишүүдийн хурал, Удирдах зөвлөл, шагналууд				
Нийт гишүүдийн хуралд оролцох	Квот: 5 төлөөлөл	Квот: 4 төлөөлөл	Квот: 1 төлөөлөл	Саналын эрхгүй
ТоС Манлайлагч байгууллагад нэр дэвших	✓	✓	✓	
Удирдах зөвлөлд нэр дэвших, санал оруулах хэлэлцүүлэх	✓	✓	✓	
“Шилдэг ТоС Байгууллага” шагналд нэр дэвших	✓	✓	✓	
ТоС Холбоонд хагас жил тутамд тайлан явуулах	✓	✓	✓	
2. Тогтвортой санхүүгийн мэргэшсэн дэмжлэг, зөвлөгөө				
Олон улсын стандартын дагуу ТоС-ийн хэрэгжилтийн түвшинг үнэлүүлэх	✓	✓	✓	
ТоС-ийн хэрэгжилтийн хүрээнд мэргэшсэн зөвлөгөө, дэмжлэг авах: <ul style="list-style-type: none"> • Байгаль орчин, нийгмийн удирдлагын систем (БОНУС)-ийг бүрдүүлэх дэмжлэг • Жишиг БОН-ийн эрсдэлийн бодлого, аргачлал, тайлагналын загвар • Ногоон бүтээгдэхүүн боловсруулах зөвлөгөө, дэмжлэг, аргачлал • Тогтвортой тайлагналын гарын авлага • Жендэрийн жишиг бодлого, гарын авлага, зөвлөмж • Ногоон оффисын гарын авлага, сайн жишээ 	✓	✓	✓	
3. Зөвлөл, ажлын хэсэг, төсөл хөтөлбөр, судалгаа				
Холбооноос хэрэгжүүлдэг төслүүдэд хамрагдах	✓	✓	✓	✓
ТоС зөвлөлд оролцох	✓	✓	✓	✓
ТоС ажлын хэсгүүдэд оролцох	✓	✓	✓	✓
Судалгааны ажилд санал өгөх, оролцох	✓	✓	✓	✓
4. Сургалт, арга хэмжээ, мэдээлэл				
Newsletter, CEO update, жилийн тайлан хүлээн авах	✓	✓	✓	✓
ТоС-ийн онлайн сургалтын платформд үнэгүй нэвтрэх	200 хүртэлх ажилтан	100 хүртэлх ажилтан	80 хүртэлх ажилтан	10 хүртэлх ажилтан
Франкфуртын их сургуулийн сургалтуудад хөнгөлөлттэй нөхцөлөөр хамрагдах	✓	✓	✓	✓
Хурал, арга хэмжээ болон сургалтуудад оролцох	Квотоор	Квотоор	Квотоор	Квотоор

***БҮЛЭГ 1:** ХААН БАНК, ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК, ГОЛОМТ БАНК, ТӨРИЙН БАНК, ХАСБАНК, БУСАД САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА;

БҮЛЭГ 2: ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК, КАПИТРОН БАНК, ХӨГЖЛИЙН БАНК, МИК, ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛЫН САН, ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИ, ГАДААДЫН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУД;

БҮЛЭГ 3: АРИГ БАНК, ЧИНГИС ХААН БАНК, БОГД БАНК, ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК, КРЕДИТ БАНК, ДААТГАЛ, ҮЦК, ББСБ-УУД ГЭХ МЭТ;

ХЭРХЭН ГИШҮҮН БОЛОХ ВЭ?

Алхам 1.

Гишүүнээр элсэх хүсэлтэй байгууллага хавсралт дахь i) анкетыг бөглөн, ii) ТоС-ийн зарчмуудыг хэрэгжүүлэх тунхаг бичигт гарын үсэг зурж, iii) албан хүсэлтийн хамт ТоС Холбоонд ирүүлнэ. Бүрдүүлэх шаардлагатай материалуудын талаар нэмэлт мэдээлэл авах бол info@toc.mn хаягаар хандах боломжтой.

Алхам 2.

Холбооны ажлын алба нь гишүүнээр элсэх өргөдөлтэй танилцаж, шаардлагатай бол нэмэлт мэдээллийг хүсэлт гаргасан байгууллагаас авна. Материалуудыг гүйцэт бүрдүүлсний дараа Хүсэлтийг Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Алхам 3.

Удирдах зөвлөлийн хурлаас элсүүлэх тухай шийдвэр гаргасан тохиолдолд албан ёсоор гишүүнээр элсэн, гишүүнчлэлийн хураамжаа төлж гишүүнчлэлийн хэлбэрээс хамааран давуу эрх, үйлчилгээг хүртэх боломжтой болно.

Алхам 4.

Үндсэн гишүүний хувьд гишүүнээр элссэнээс хойш 12 сарын дотор Холбооноос баталсан Хавсралт 3 дахь "Гишүүнчлэлийн суурь шаардлагууд"-ыг хэрэгжүүлнэ. Холбооны ажлын албанаас үнэлгээ, сургалт, зөвлөмжүүдийг өгнө. Холбоонд хагас жил тутамд ТоС-ийн хэрэгжилтийн тайланг ирүүлнэ.

ГИШҮҮНЧЛЭЛЭЭС ЧӨЛӨӨЛӨХ

Дараах тохиолдолд гишүүнчлэл дуусгавар болно. Үүнд:

- Гишүүн өөрөө чөлөөлөгдөх хүсэлтээ Гүйцэтгэх захирал, Удирдах зөвлөлийн дарга эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтны гарын үсэгтэй бичгээр гаргасан
- Холбооны нэр хүнд, эрхэм зарилго, үндсэн чиглэлд харшилсан үйл ажиллагаа явуулсан, ашиг сонирхлын зөрчилд автсан зэрэг нь тогтоогдсон
- Хуулийн этгээд байгууллага татан буугдсан, дампуурсан
- Гишүүнчлэлийн татвараа тогтоосон хугацаанаас хойш 6 сарын дотор төлөөгүй тохиолдолд сануулга өгч гишүүнчлэлээс түдгэлзүүлэх бөгөөд энэ хугацаанаас хойш 3 сарын дотор авлагыг барагдуулаагүй тохиолдолд гишүүнчлэлээс чөлөөлнө.

ХАВСРАЛТ 1: ӨРГӨДЛИЙН МАЯГТ

1. БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр:

Элсэх хүсэлтэй гишүүнчлэлийн төрөл:

Үндсэн гишүүн Дэмжих гишүүн

Үндсэн гишүүний бүлэг (Хэрвээ үндсэн гишүүн бол): Бүлэг I Бүлэг II Бүлэг III

Байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл:

Арилжааны банк Хөгжлийн банк Гадаадын банкны төлөөлөгчийн газар

ББСБ Хадгаламж, зээлийн хоршоо Хөрөнгийн оруулалтын менежментийн компани

Тусгайн зориулалтын санхүүгийн байгууллага (тодорхойлох) _____

Даатгалын компани Үнэт цаасны компани

Бусад санхүүгийн байгууллага (тодорхойлох) _____

Мэргэжлийн, салбарын холбоо Бизнесийн байгууллага

ТББ, Сан, Иргэний нийгмийн байгууллага Олон улсын байгууллага

Их дээд сургууль. Судалгаа шинжилгээний хүрээлэн

Бусад (тодорхойлох) _____

2. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Танай байгууллагын ажиллах хүсэлтэй тэргүүлэх үйл ажиллагааны чиглэл (Холбооны брошураас үндсэн 6 чиглэлийн талаар нэмэлт мэдээлэл авах боломжтой)

Тогтвортой санхүүгийн зарчим, стандарт хэрэгжүүлэх

Ногоон санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, санхүүжилт олгох

Тогтвортой бизнесийн салбаруудыг дэмжих, хөгжүүлэх

Тогтвортой санхүүжилтийн бодлогын орчны бүрдүүлэх

Сургалт, мэдээллийн үйл ажиллагаанд хамрагдах

Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх

Бусад _____

Байгууллага болон үндсэн үйл ажиллагааны талаар товч танилцуулга (150 үгэнд багтаах). *Тос Холбооны вебсайтад байршуулна*

Байгууллагын тогтвортой санхүүжилт, бизнесийн стратеги, зорилт, одоог хүртэл хийсэн ажлууд, ToC Холбоонд гишүүнээр элссэнээр ажиллах хүсэлтэй байгаа чиглэлүүдийн талаар товч тайлбарлана уу (150 үгэнд багтаах).

--

Оролцох хүсэлтэй ажлын хэсэг, зөвлөлүүдийг сонгоно уу.
(Холбооны брошураас ажлын хэсэг, зөвлөлүүдийн талаар нэмэлт мэдээлэл авах боломжтой)

<input type="checkbox"/> ТоС Зөвлөл Төлөөлж оролцох ажилтны нэр, албан тушаал, имэйл хаяг
<input type="checkbox"/> Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын ажлыг хэсэг Төлөөлж оролцох ажилтны нэр, албан тушаал, имэйл хаяг
<input type="checkbox"/> Тогтвортой тайлагналын ажлын хэсэг Төлөөлж оролцох ажилтны нэр, албан тушаал, имэйл хаяг
<input type="checkbox"/> Ногоон бодлогын ажлын хэсэг Төлөөлж оролцох ажилтны нэр, албан тушаал, имэйл хаяг
<input type="checkbox"/> Ногоон бүтээгдэхүүний ажлын хэсэг Төлөөлж оролцох ажилтны нэр, албан тушаал, имэйл хаяг
<input type="checkbox"/> Ногоон цахим бүтээгдэхүүний ажлын хэсэг Төлөөлж оролцох ажилтны нэр, албан тушаал, имэйл хаяг
<input type="checkbox"/> Ногоон оффисын ажлын хэсэг Төлөөлж оролцох ажилтны нэр, албан тушаал, имэйл хаяг
<input type="checkbox"/> ПиАр, мэдээллийн ажлын хэсэг Төлөөлж оролцох ажилтны нэр, албан тушаал, имэйл хаяг
<input type="checkbox"/> Бусад үүсгэх байгуулах хүсэлтэй ажлын хэсэг _____ Төлөөлж оролцох ажилтны нэр, албан тушаал, имэйл хаяг

3. ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ

Төв байрны хаяг			
Байр, хороо, дүүрэг			
Хот		Аймаг, хот	
Шуудан (postal code)		Улс	
Веб сайт			
Байгууллагын гүйцэтгэх захирал			
Овог			
Нэр			
Албан тушаал			
И-мэйл			
Утас			
Тос Холбоотой харилцах удирдлагын түвшний ажилтан			
Овог			
Нэр			
Албан тушаал			
И-мэйл			
Утас			
Тос Холбоотой шууд харилцах ажилтан			
Овог			
Нэр			
Албан тушаал			
И-мэйл			
Утас			
Мэдээлэл, PR харилцааны холбогдох ажилтан (мэдээ, материал, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг түгээх г.м)			
Овог			
Нэр			
Албан тушаал			
И-мэйл			
Утас			
Утас			
Хүний нөөц, маркетинг, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хууль, IT, зээл, эрсдэл, комплайнс, төсөл, хангамж ба ложистикийн холбоо барих ажилтнууд			
Хамтын ажиллагаатай холбоотой мэдээлэл (newsletter гэх мэт.) хүлээн авах шаардлагатай нэмэлт ажилтнуудын мэдээллийг оруулна уу.			
Овог	Нэр	Албан тушаал	И-мэйл

4. ГАРЫН ҮСЭГ

Манай байгууллага ToC Холбоонд элсэж, ToC-ийн зарчмуудад нэгдэн, хэрэгжүүлэх хүсэлтээ энэ өргөдлөөр дамжуулан албан ёсоор хүргүүлж байна.

Нэр (Албан тушаал)

Гарын үсэг

Он сар өдөр

АЖЛЫН АЛБАНЫ ТЭМДЭГЛЭГЭЭ

Хүсэлтийг хүлээж авсан он, сар, өдөр:

Хүсэлтийг баталгаажуулсан он, сар, өдөр:

Хүсэлтийн бүртгэлийн дугаар:

Бүрдүүлэх материал бүрэн эсэх:

Нэхэмжлэх хүргүүлсэн эсэх:

Хүсэлтийг хүлээн авсан ажилтан: Нэр _____ Гарын үсэг _____

ХАВСРАЛТ 2. ТоС-ИЙН ЗАРЧМУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУНХАГ БИЧИГ

Бид цаг уур, байгаль орчин, нийгэм, эдийн засагт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх оновчтой шийдлийг эрэлхийлж, эрүүл аюулгүй, ногоон орчинд ажиллаж, амьдрах боломжийг бүрдүүлэхийн төлөө нэгдэж, бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагаа, хамтран ажиллаж буй харилцагч, үйлчлүүлэгчдээрээ дамжуулан Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудад нэгдэж, үр дүнтэй хэрэгжүүлэхээ үүгээр тунхаглаж байна.

ТоС-ИЙН 8 ЗАРЧИМ

Зарчим 1. Байгаль орчноо хамгаалах

Бид хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй, шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.

Зарчим 2. Хүний эрх, нийгмийг хамгаалах

Бид хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөнө. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллана.

Зарчим 3. Соёлын өвийг хамгаалах

Бид Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн соёл, түүх, археологи, палентологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалан ажиллана.

Зарчим 4. “Ногоон эдийн засгийг”-ийн өсөлтийг дэмжих

Бид Монгол Улсын ногоон, цэвэр эдийн засагт хувь нэмэр оруулах төсөл болон бусад үйл ажиллагааг дэмжин ажиллана.

Зарчим 5. Санхүүгийн бүтээмжийг дэмжих

Бид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, санхүүгийн боловсрол олгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээг авах замаар Монгол Улсад санхүүгийн өргөн хүрээтэй тогтолцоог бий болгохыг дэмжин ажиллана.

Зарчим 6. Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих

Бид хориглосон жагсаалтанд багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, бид ёс суртахуунгүй, гэмт хэргийн шинж чанартай үйлдлийг үл тэвчих бодлого явуулж, ёс зүйтэй байх, компанийн засаглалтай холбоотой сайн туршлагуудыг дэмжих бодлого баримтлан ажиллана.

Зарчим 7. Ил тод байдал, хариуцлагыг дэмжих

Бид ил тод байдал, хариуцлагыг дэмжин, банкны Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах явдлыг дэмжин ажиллана.

Зарчим 8. Манайлан үлгэрлэх

Бид харилцагчиддаа тавьж буй шаардлагыг өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, салбарын хувьд Монгол Улсыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд эерэг хөгжилд чиглүүлэн ажиллана.

Нэр (Албан тушаал)

Гарын үсэг

Он сар өдөр

ХАВСРАЛТ 3. ГИШҮҮНЧЛЭЛИЙН СУУРЬ ШААРДЛАГА

(ЗӨВХӨН ҮНДСЭН ГИШҮҮНД ХАМААРНА)

Бид ToC Холбоонд албан ёсоор гишүүнээр элссэнээс хойш 12 сарын дотор доорх гишүүнчлэлийн суурь шаардлагуудыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

No.	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Статус
0.	Ерөнхий бэлтгэл	
0.1	Гишүүнчлэлийн төлбөр төлөх /гишүүнчлэлийн ангиллаас дүн хамаарна/	
0.2	Гишүүн байгууллагаас ToC Холбоотой ажиллах төлөөллийг албан ёсоор томилох	
0.3	Байгууллагын нэр, лого, товч танилцуулгыг Холбоонд явуулах, Холбооноос цахим хуудсанд байршуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	
0.4	Хамтын ажиллагааг эхлүүлэх ажлын уулзалтыг зохион байгуулах	
1.	Тогтвортой санхүүжилтийн тогтолцоо	
1.1	ToC-ийн зарчмуудыг тусгасан бодлого, журмыг боловсруулж батлах (ToC Холбооноос жишиг бодлогын загвар өгөх)	
1.2	Тогтвортой санхүүжилтийн ажлыг хариуцах бүтэц, орон тоог баталж, бий болгох (бүтэн цагийн эсвэл, хавсарсан байдлаар)	
1.3	ToC-ийн зарчмуудыг тусгасан Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулж, батлах (ToC Холбооноос жишиг аргачлал өгөх)	
1.4	Тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой ажлын төлөвлөгөө гаргах	
2.	Сургалт	
2.1	Ажилтнууд, харилцагчдад зориулсан сургалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	
2.2	ToC Холбооны онлайн сургалтад холбогдох ажилтнуудыг хамруулах	
2.3	ToC-ийн танхимын сургалтад хамрагдах (байгууллагад тусгайлан зориулсан)	
3.	Мэдээллийн арга хэмжээнүүд	
3.1	ToC гишүүний логог байгууллагын вебсайтад байршуулна /Логог ToC Холбооноос авна/	
3.2	Байгууллагын гүйцэтгэх удирдлагаас тогтвортой санхүүжилттэй холбоотой зорилго, бодлого болон хэрэгжүүлэх ажлуудын талаар дурьдсан мэдэгдэлийг байгууллагын вебсайтад байршуулах /Энэхүү мэдэгдэл нь зурвас, ярилцлага, видео, нийтлэл гэх мэт ямар ч хэлбэрээр байж болно./	
3.3	Байгууллагын ажилтан, харилцагч, олон нийтэд мэдээлэл өгөх арга хэмжээнүүдийг зохион байгуулах	
4.	Хяналт, тайлагнал	
4.1	Байгууллагын тогтвортой санхүүжилтийн бодлогын хэрэгжилтэд тогтмол хяналт тавих механизмыг бүрдүүлэх	
4.2	Хагас жил тутамд тогтвортой санхүүжилтийн бодлогын хэрэгжилтийн талаар тайлан, мэдээг ToC Холбоонд ирүүлэх /өгөгдсөн маягтын дагуу/	
4.3	Тогтвортой санхүүжилтийн бодлогын хэрэгжилтийн талаар тайлан, мэдээг байгууллагын жилийн эцсийн тайланд оруулах /Холбооноос зөвлөмж өгнө/	
4.4	Тогтвортой санхүүжилтийн бодлогын хэрэгжилтийн талаар тайлан, мэдээг байгууллагын вебсайтад байршуулах.	

*Дээрх ажлууд нь ToC Холбооны гишүүнчлэлтэй холбоотой босго шаардлагууд тул гишүүд өөрийн тогтвортой санхүүжилтийн бодлогоос хамааран бусад ажлуудыг зохион байгуулах боломжтой

Нэр (Албан тушаал)

Гарын үсэг

Он сар өдөр